



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны
удирдлагын тогтолцооны журам

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

1 ЗОРИЛГО

Газар хөндөх үйл ажиллагааны зохицуулалт, түүнд шаардагдах стандарт, журам зэргийг тодорхойлох, Газар Хөндөх Зөвшөөрлийг олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар газар ашиглах үйл ажиллагааны үр дүнтэй хэрэгжилтийг Оюу Толгой ХХК-ийн (ОТ) түрээслэн ашиглаж байгаа болон хариуцаж байж болох бүх газруудад тогтвортой удирдан зохицуулахад оршино.

1.1 Зорилтууд

Уг журмыг хэрэгжүүлж ОТ дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Холбогдох бүх эрх зүйн болон стандарт шаардлагуудыг сахиж мөрдөх;
- Үйл ажиллагааны нөлөөллийн улмаас учирч болзошгүй хөрсний элэгдэл, эвдрэлийг хамгийн бага байлгах;
- Өнгөн/шимт хөрсийг хамгаалах болон түүнийг цаашдын нөхөн сэргээлт, уурхайн хаалтад зориулан хадгалах;
- Усны нөөц, биологийн олон янз байдал, соёлын өв болон орон нутгийн иргэдийн сайн сайхан байдалд Газар хөндөх үйл ажиллагааны улмаас үүсч болзошгүй нөлөөллийг багасгах, боломжтой бол урьдчилан сэргийлэх;
- Байгаль орчны удирдлагын тэргүүн зэргийн туршлагыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ОТ компанийн боловсруулан гаргасан ЭМААБО-ны бодлогыг дагаж мөрдөх;
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННУ) тусгасан шаардлагуудыг дагаж мөрдөх.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

Газар хөндөх зөвшөөрөл олгох журамд газар хөндөхтэй холбоотой үндсэн суурь шаардлагуудыг тусгасан бөгөөд эдгээр шаардлагуудыг компанийн дотоодын зөвшөөрлийн тогтолцоотой уялдуулан оруулсан болно. Энэхүү журам нь барилга угсралт, уурхайн ашиглалт, хаалтын үе шатуудад ОТ компанийн үйл ажиллагаанд өртсөн хөндөгдөөгүй, нөхөн сэргээгдсэн газруудад хамаарч үйлчилнэ. ОТ-н газар зүйн мэдээллийн санд хөндөгдсөн талбайн ангилалд бүртгэгдээгүй боловч өмнө нь хөндөгдсөн газарт төлөвлөгдсөн үйл ажиллагаануудад мөн энэ журмыг дагаж мөрдөнө.

Энэхүү журмыг мөн ОТ болон түүний нэр дээрх бусад уурхайтай үл холбогдох төслүүд, түүнчлэн аливаа гуравдагч талын мэдэлд шилжүүлэх ОТ компанийн байгуулсан аливаа байгууламжид дагаж мөрдөнө. (Үүнд: төрийн удирдах/хууль тогтоох чиг үүргийн байгууллага, сургалтын институц, Гүйцэтгэгчдийн барилга байгууламж, орон нутгийн байгууллагууд орно)

Энэхүү журмыг ОТ-н бусад дотоод журам, тэр дотроо дараах журмын хамт хэрэглэнэ. Үүнд:

- Ховор ургамлыг хамгаалах журам (ОТ-10-Е14-PRC-0007);
- Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний журам (ОТ-0244-00-SWPO-0008)
- Өнгөн хөрстэй ажиллах журам (ОТ-10-Е14-PRC-0001);
- Техникийн нөхөн сэргээлтийн журам (ОТ-10-Е14-PRC-0002);
- Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам (ОТ-10-Е15-PRC-0002)
- Дурсгалт зүйл олдсон тохиолдолд баримтлах журам (лавлах дугаар байхгүй);
- Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (ОТ-Е14-PLN-0005)

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

- Уурхайг хаах төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0002)
- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0003)
- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е11-PLN-0001)
- Агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е12-PLN-0001);

3 АЖИЛ ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА

Ажил үүрэг	Хариуцлага
Газарт нөлөөлөл үзүүлж буй төслүүдийг зохицуулах ОТ-н баг	<ul style="list-style-type: none"> • Ховор ургамлын зүйлст нөлөөлөл учруулахаас зайлсхийх бөгөөд бүх төслийн төлөвлөлтийн шатанд Оюу Толгойн ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн багийнхантай зөвлөлдөх. • Ховор ургамлын зүйлст нөлөөлөл учруулахаас зайлсхийх боломжгүй тохиолдолд, бүх төслийн төлөвлөлтийн шатанд Оюу Толгойн ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн багийнхантай төслийн эхлэх хугацааг зөвлөлдөх. • ГХЗ олгох бүх үе шатанд Байгаль орчны хэлтэс, Газар шорооны ажил хэрэгжүүлэх баг, Гүйцэтгэгчидтэй харилцах. • ГХЗ-ийн хүсэлтийн маягыг бүрэн бөглөж, гарын үсэг зурж баталгаажуулан шаардлагатай бусад материалын хамт ирүүлэх. • Газар шорооны ажил хийх хүмүүсийг тухайн санал болгосон ажилтай нь холбоотой мэдээллээр хангах (батлагдсан ГХЗ, тайлан, газрын зураг, удирдамж, сургалт г.м) • Тухайн ажлыг эхлэхээс өмнө Ажлын аюул эрсдлийн үнэлгээ болон бусад ажилтай холбоотой байгаль орчны үнэлгээ хийлгэх • Газар шорооны оператор, гүйцэтгэгч нарыг батлагдсан ГХЗ-д заасан шаардлагын дагуу ажиллуулахын тулд ГХЗ-ийн эрх зүйн хэрэгжилтийн шалгалт хийж, шалгалт бүрийн дараа Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтанд мэдэгдэх.
ЭМААБОАБОН-н Ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> • ОТ-н ЭМААБОАБОН-ийн хэлтсийн удирдлагаар энэхүү журмыг дагаж мөрдүүлэх
Байгаль орчин, биологийн олон янз байдлын менежер	<ul style="list-style-type: none"> • ОТ-н үйл ажиллагаанд энэхүү журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. • Байгаль орчны мэргэжилтний албан үүрэг гүйцэтгэгчийг эзгүйд ГХЗ-ийг хянаж, батлах.
Байгаль орчны мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> • Шаардлага гарвал ЭМААБОАБОН-ийн удирдлагатай зөвшилцөж энэ журмыг шинэчлэх. • ГХЗ-ийг хянаж, батлах.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

	<ul style="list-style-type: none"> • Техникийн нөхөн сэргээлт амжилттай хийгдсэн газруудын ГХЗ-ийн техникийн нөхөн сэргээлтийн эцсийн тайланг хянаж, гарын үсэг зурах.
Байгаль орчны ажилтан-Газар хариуцсан	<ul style="list-style-type: none"> • ГХЗ хүлээж авч, бүртгэж, гүйцэлдүүлэх. • Төлөвлөсөн ажлын талбайд газар хөндөлтийн өмнөх байгаль орчны шалгалт хийх. • ГХЗ-ийг батлуулахад зөвшөөрлийн шаардлагуудыг тодорхойлох. • Техникийн нөхөн сэргээлт, ГХЗ-ийн гүйцээлтийн шалгалт явуулах, холбогдох талуудад нөхцөл байдлын талаар мэдээллэх • Талбайгаас гадуурх төслүүдийн хувьд, техникийн нөхөн сэргээлт амжилттай дууссаны дараа Улсын хяналт хийлгэхэд зориулж ЭМААБО-ны эрх зүй, зөвшөөрөл хариуцсан багт тайланг хүргүүлнэ. • ГХЗ бэлтгэж хаалтын гарын үсэг зуруулах, хаагдсан хуулбарыг холбогдох багуудад тараах • ГХЗ-ийн баримт бичгийг цахим болон хэвлэмэл хувиар хадгалах.
GIS ажилтан	<ul style="list-style-type: none"> • ГХЗ хүсэх маягад заасан байршил, газар нутгийн мэдээллийн үнэн зөв байдлыг шалгаж баталгаажуулах. • Төлөвлөсөн ажлын хэрэгжилт, техникийн нөхөн сэргээлт зэрэг ажлын үед газар хөндөлтийн өмнөх үе шат болон ГХЗ олгох бүх үе шатанд шаардлагатай газрын зургуудыг бэлтгэх. • Газар хөндөх, нөхөн сэргээлт хийх газар зүйн мэдээллийн санг хадгалах.
Ургамлын аймгийн судалгааны баг	<ul style="list-style-type: none"> • Цаашдын газар хөндөх төслийн талбай дахь биологийн олон янз байдлын судалгааг эрт төлөвлөх зорилгоор Оюу Толгойн барилгын инженерийн групп болон бусад хэлтсүүдтэй тогтмол харилцаа холбоотой (улирал тутам хянах) байх. • Ховор ургамлын зүйлст нөлөөлөл учруулах эрсдэлээс зайлсхийх боломжгүй тохиолдолд уг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, төслийг эхлүүлэх хугацаатай холбоотойгоор төслийн талбайг сонгоход Төслийн зохицуулах багуудад зөвлөх. • Хөрсний төрөл, өнгөн хөрсний гүн, талбай, ургамлан бүрхэвчийн бүлэг, ховор ургамлын төрөл зүйл хамгааллын асуудлыг харгалзаж ГХЗ хүссэн газар дээр мэргэжлийн тайлбар гаргаж, түүнийг гарын үсэгтэй ГХЗ батлах байгаль орчны шалгах хуудаст тусгах • ГХЗ-д заасан нөхцөлүүдэд нийцүүлж өнгөн хөрс шилжүүлэлтийн Өнгөн хөрсний бүртгэлийн хуудас хөтлөх. • Төлөвлөсөн ажлын талбайд илэрсэн ховор ургамлын төрөл

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

	<p>зүйлийг шилжүүлэн суулгах үүрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> • ГХЗ-ийг гүйцэлдүүлэх буюу техникийн нөхөн сэргээлтэд оролцож, биологийн нөхөн сэргээлтийн урьдчилсан нөхцөлийг хангасан эсэхийг баталгаажуулж бичгээр тодорхой тайлбар гаргах
Амьтны аймгийн судалгааны баг	<ul style="list-style-type: none"> • Зэрлэг ан амьтдын болон амьдрах орчны хамгааллын асуудлыг харгалзан гарын үсэг зурсан ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудасны маягтын ГХЗ хүссэн газар дээр мэргэжлийн дүгнэлт өгөх.
Усны нөөцийн баг	<ul style="list-style-type: none"> • Усны нөөц, суурилуулсан хяналтын цэгүүдийг хамгаалах зорилгоор ГХЗ хүсэх материалыг хянаж, гарын үсэг зурсан ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудас дээр тодорхой дүгнэлт, эцсийн тайлбар хийх.
Хог хаягдал, химийн бодисын баг	<ul style="list-style-type: none"> • Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн явцад харгалзан үзэх шаардлагатай хог хаягдал, химийн бодисын удирдлагын шаардлагуудыг гарын үсэг зурсан ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудасны маягт дээр тайлбарлах.
ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилт хариуцсан баг	<ul style="list-style-type: none"> • Төлөвлөсөн ажлыг эхлүүлэхэд холбогдох эрх зүйн хэрэгжилтийн шаардлагуудыг тодорхойлохын тулд ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилтийн шалгах хуудсыг ашиглан ГХЗ-ийн хүсэлтийн материалыг бүрэн хянаж, улмаар гарын үсэг зурсан ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудасны маягт дээр Газар хариуцсан багт дүгнэлт тайлбар өгөх. • Шаардлага гарвал, ГХЗ-ийн хүсэлт гаргагчдын тайлбар, илэрсэн эрх зүйн хэрэгжилтийн шаардлагууд дээр шаардлагатай тайлбарыг тэдэнд өгөх. • Газар болон Ургамлын багуудын хийсэн дотоод шалгалтаар хүлээн зөвшөөрөгдсөн техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газрууд дээр Улсын шалгалт хийлгэх ажлыг зохицуулах. • ГХЗ-ийн хүсэлтийг хаах Газар хариуцсан баг зэрэг холбогдох талуудад Орон нутгийн засаг захиргааны гаргасан Нөхөн сэргээлтийн актыг өгөх.
Нийгмийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> • ОТ–н тусгай зөвшөөрлийн талбайн гадна газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө холбогдох ард иргэд, орон нутгийн оролцогч талуудад мэдэгдэж, шаардлагатай бол олон нийтийн хэлэлцүүлэг явуулна. • ГХЗ олгох олон нийтийн шалгах хуудсанд тодорхойлсон бүх сэдвээр санал, дүгнэлтийг бичгээр гаргана. Тухайн сэдэвт тухайн ажлын талаар хийсэн олон нийтийн зөвлөгөө, дуу шуугиан ихтэй үйл ажиллагаа, өвөлжөө/зуслан, малчдын худаг, соёлын өвийг шилжүүлэх болон бусад ажил хамаарна • ОТ–н тусгай зөвшөөрлийн талбайн гаднах газар хөндөх үйл ажиллагаа явуулах шаардлагатай бол энэ талаар орон нутгийн засаг захиргааны удирдлагатай хийх

Хуудас 5-22

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

	<p>уулзалтад оролцоно.</p> <ul style="list-style-type: none"> • Газар шорооны ажил хариуцсан баг, Гүйцэтгэгчдэд орон нутаг, соёлын өвийн талаарх танилцуулах сургалт хийнэ. • Төлөвлөсөн ажлын талбайн ойролцоо соёлын өвийн дурсгал илэрвэл, Газар шорооны ажил хариуцсан баг, Гүйцэтгэгчийг соёлын өвийг хамгаалах шаардлагын дагуу ажиллуулж, хяналт тавина • Нөхөн сэргээлтийн шалгалт зэрэг ГХЗ-ийн хүсэлтийг гүйцээх ажиллагаанд оролцож, нөхөн сэргээлтийн нөхцөл байдалд олон нийтийн харилцааны хандлагаас бичгээр өгсөн тайлбарыг Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтанд өгнө.
Газар хөндөх үйл ажиллагааг гүйцэтгэж буй операторуудын ахлах ажилтнууд	<ul style="list-style-type: none"> • Газар шорооны ажлын гүйцэтгэгчид энэхүү журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллана. • Өдөр тутмын ажлыг эхлүүлэхийн өмнө ГХЗ-ийн хамрах хүрээ, шаардлагын талаар газар шорооны ажил операторуудад ойлгуулж таниулна. • ГХЗ-д нийцсэн, хүлээн зөвшөөрч болох болон хүлээн зөвшөөрч болохгүй ажлын аргуудыг тодорхойлж, мэдээлнэ. • Газар шорооны ажилд зохих техник, тоног төхөөрөмж ашиглаж ажиллуулна. • Шаардлагатай үед газар шорооны ажлын операторуудад өнгөн хөрсийг хуулах, тээвэрлэх, овоолох журмын талаар зааварчилгаа өгч мөрдүүлнэ. • ГХЗ-ийн хугацаанд бороо устай нөхцөлд тухайн ажлын талбайд хамгаалах арга хэмжээг Ус, салхины элэгдлээс хамгаалах төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлж, мөрдүүлнэ. • Газар шорооны ажлын операторуудыг хувийн хамгаалах хэрэгсэл болон ерөнхий хамгаалах хэрэгслээр хангана. • ГХЗ-ийн биелэлт ба Техникийн нөхөн сэргээлтийн хяналт шалгалтын тайланд тусгагдсан шаардлагуудыг хэрэгжүүлж, шаардлагатай ажлыг хийж дууссан талаар Төслийн зохицуулах багт мэдэгдэнэ.
Газар хөндөх үйл ажиллагааг гүйцэтгэж буй операторууд	<ul style="list-style-type: none"> • ГХЗ-д заасан шаардлагуудыг дагаж мөрдөх. • Газар хөндөх үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох бүх журмыг хэрэгжүүлэх. • Газар хөндөх үйл ажиллагааг гүйцэтгэхдээ Ахлах ажилтны өгсөн зааврыг биелүүлэх.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

Сургалтын хэлтэс	<ul style="list-style-type: none">Үндсэн ба гэрээт ажилтнуудад газар шорооны ажилтай холбоотой байгаль орчны менежментийн талаар танилцуулах сургалт явуулах
------------------	--


4 ЖУРАМ

Газар хөндөх аливаа үйл ажиллагаа, тэр дундаа ОТ-оос болон түүний өмнөөс хөндөгдөөгүй болон нөхөн сэргээлт хийгдсэн газрыг хөндөхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах шаардлагатай. Энэхүү журам нь Газар хөндөх зөвшөөрлийг хаах хүсэлтийн алхмуудаас эхлээд үйл явцыг нарийвчлан тодорхойлох бөгөөд үүнд дараах алхмууд багтана. Үүнд:

1. ГХЗ-ийн хүсэлт
2. ГХЗ-ийг хянах
3. ГХЗ-ийг батлах
4. Газар хөндөх
5. Техникийн нөхөн сэргээлт хийх
6. ГХЗ-ийг хаах

Эдгээр алхмуудын хоорондын уялдаа, дарааллыг дараах "Газар хөндөх зөвшөөрлийг батлах, хаах дараалал" схемд үзүүлж, энэ хэсгийн тус тусын нэрээр нь нарийвчилж харууллаа.

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2



Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

4.1. ГХЗ-ийн хүсэлт

Төлөвлөсөн ажлын төслийг зохицуулж буй баг (цаашид Төслийн зохицуулах баг гэх) бүрэн бөглөж, газрын үсэг зурсан ГХЗ-ийн хүсэлтийн маягтыг (Хавсралт С), түүнд заасан бусад холбогдох материалын хамтаар ОТ-н Байгаль орчны хэлтсийн Газрын асуудал хариуцсан багт ирүүлнэ.

Өнгөн хөрсний удирдлагын төлөвлөгөө, тунадас хянах төлөвлөгөө нь бүх төрлийн газар хөндөх үйл ажиллагааны ГХЗ-ийн хүсэлтэд заавал байх ёстой бүрэлдэхүүн хэсгүүд юм. Төслийн зохицуулах баг нь ОТ-н Байгаль орчны багийн бэлтгэсэн загварыг (Хавсралт В) ашиглаж өнгөн хөрсний удирдлагын төлөвлөгөөг тухайн газарт тусгайлан бэлтгэнэ. ГХЗ-ийн хүсэлтийн маягтын холбогдох хэсэг дэх ус, салхины элэгдлээс хамгаалах төлөвлөгөөнд дараах мэдээллийг оруулах ёстой. Үүнд:

- Уулын үер, элэгдлээс хамгаалах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө
- Тодорхойлон заасан Ус болон салхины элэгдлээс хамгаалах бүх арга хэмжээний зураглал
- Тоног хэрэгслийг суурилуулах, дараа нь буцааж авах ажлын төлөвлөгөө

4.1.1. Төслийн талбай дээрх төслүүд

ГХЗ-ийн хүсэлтийг уг журмын дагуу үнэлж, хянах зорилгоор төлөвлөсөн ажлын эхлэхээс хамгийн багадаа 2 долоо хоногийн өмнө төслийн талбай дээрх төслүүдийн ГХЗ-ийн хүсэлтийг ирүүлнэ.

ГХЗ-ийн хүсэлтийг ирүүлэхээс өмнө хэрэв ховор ургамлын төрөл зүйл олдсон бол Төслийн зохицуулах баг газар хөндөхөөс зайлсхийх боломжийг судалж, ховор ургамлын урьдчилсан судалгаа хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор төлөвлөсөн ажлын талбайн төлөвлөгөөнд газрын зураг оруулан Ургамлын аймаг судалгааны багт зааж өгөх ёстой. Урьдчилсан судалгаа нь ямар нэг ховор ургамлын төрөл зүйл байгаа эсэхийг тодорхойлох, хэрэв байгаа тохиолдолд газар хөндөхөөс зайлсхийж, бууруулах арга хэмжээний тал дээр зөвлөгөө гаргах зорилготой. ОТ-н уурхайн эзэмшлийн талбай дотор тогтоогдсон ховор ургамлын төрөл зүйлийн байршлыг Хавсралт А-аас, нөлөөллийг бууруулах шаталсан арга хэмжээний дарааллыг 4.2.3.1-р хэсгээс үзнэ үү.

4.1.2. Төслийн талбайгаас гадуурх төслүүд

Төслийн талбайгаас гадна ГХЗ-ийг авахын тулд ОТ-н Байгаль орчны хэлтэст ГХЗ-ийн хүсэлтийг ирүүлсний дараа засгийн газрын агентлагуудаас зөвшөөрөл авах зэргээр газар хөндөх ажлыг хөндлөнгийн байгууллагаар батлуулах, БОНБНУ-ний тавигдах шаардлага байдгаас шалтгаалан хамгийн багадаа 1 сарын хугацаа шаардлагатай байдаг.

Биологийн олон янз байдалд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах ОТ-н шаталсан арга хэмжээний дагуу тухайн талбайд олдсон аливаа ховор ургамлын төрөл зүйлийг хөндөхөөс сэргийлэх зорилгоор төслийн талбайгаас гадуурх төслийн байршлыг сонгохдоо төлөвлөлтийн эхний үе шатанд ОТ-н Ургамлын аймаг судалгаа, нөхөн сэргээлтийн багтай зөвшилцөх ёстой. Төслийн зохицуулах баг ховор ургамлын урьдчилсан судалгаа хийх боломжтой болгохын тулд төлөвлөсөн ажлын талбайн газрын зураг дээр тухайн газрыг Ургамлын аймгийн судалгааны багт зааж өгнө. Урьдчилсан судалгаа нь ямар нэг ховор ургамлын төрөл зүйл байгаа эсэхийг тодорхойлох, хэрэв байгаа тохиолдолд газар

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

хөндөхөөс зайлсхийж, бууруулах арга хэмжээний тал дээр зөвлөгөө гаргах зорилготой. Ховор ургамал олдсон боловч нөлөөллийг зайлуулах боломжгүй бол тухайн төслийг хойшлуулж ховор ургамалыг шилжүүлэн суулгасны дараа эхлүүлэхээр товыг гаргах ба энэ замаар ОТ-н Ховор ургамлыг хамгаалах журмын (ОТ-10-Е14-PRC-0007) дагуу шилжүүлсэн суулгасан ховор ургамлын ургалтыг хамгийн дээд хэмжээнд байлгах боломжтой юм.

4.2. ГХЗ-ийн хүсэлтийг хянах

ГХЗ-ийн хүсэлтийг хянахдаа ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилт, байгаль орчны шаардлага, олон нийтийн оролцоог харгалзаж үзэхийн тулд янз бүрийн салбарын мэргэжилтнүүдийг татан оролцуулдаг.

4.2.1. GIS хяналт

ГХЗ-ийн хүсэлтийг хүлээж авсныхаа дараа GIS ажилтан төлөвлөсөн ажлын талбайд заасан координатуудыг Оюу Толгойн Газрын менежментийн газар зүйн мэдээллийн санд оруулж, зохих газрын зургийг бэлтгэх замаар холбогдох ГХЗ-ийн хүсэлтийн маягтад өгөгдсөн газар нутгийн болон газар зүйн байршлын мэдээллийн үнэн зөв байдлыг нягтална. Төлөвлөсөн ажлын талбай нь Оюу толгойн одоо байгаа газар хөндөх бүртгэлтэй газарт байрладаг бол тухайн ГХЗ-ийг батлах шаардлагагүй.

GIS ажилтан төлөвлөсөн ажилд ГХЗ шаардлагатай гэдгийг баталгаажуулбал, Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтан төлөвлөсөн ажлын мэдээллийг Салбарын мэргэжилтнүүдийн багт хүргүүлж, зөвшөөрөл олгох эсэх тал дээр шийдвэр гаргах боломжтой болгохын тулд тэдгээрийн мэргэжлийн тайлбарыг цуглуулах бөгөөд хэрэв зөвшөөрөл олгогдвол зөвшөөрлийн нөхцөлд тайлбарыг оруулна.

Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтан ГХЗ-ийн хүсэлтэд өгөгдсөн төлөвлөсөн ажлын талбайн байршлын мэдээллийг газар дээр нь очиж нягтална. Газар дээр нь очиж шалгах явцдаа газар хөндөхийн өмнөх газрын төрх байдлын гэрэл зургийг авч, Газар хөндөхийн өмнөх хээрийн шалгалтын тайланд (Хавсралт D) тусгаж баримтжуулна.

4.2.2. ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилтэд анхаарах зүйлс

ОТ төслөөс удирдан явуулж буй бүх газар хөндөх үйл ажиллагааг Монгол улсын холбогдох хууль, журам, стандартууд, тэдгээрийг тусгасан БОННУ-ний удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсон шаардлагуудын дагуу гүйцэтгэнэ. ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилт хариуцсан баг хүлээж авсан ГХЗ-ийн хүсэлтийг хянаж уг ажиллагаанд тусална.


ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилт хариуцсан баг ГХЗ-ийн хүсэлтийн материалыг нэг бүрчлэн хянаж, ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилтийн хяналтын хуудсан (Хавсралт E) дээр тодорхой илэрхийлсэн дүгнэлт тайлбар өгч, гарын үсэг зурна.

Шаардлагатай бол, эрх зүйн хэрэгжилт хариуцсан баг өөрсдийн дүгнэлт болон тогтоосон эрх зүйн хэрэгжилтийн шаардлагууд дээр шаардлагатай тайлбарыг Төслийн зохицуулах багт өгнө.

ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилт хариуцсан баг дараах арга хэмжээний дарааллын дагуу ГХЗ-ийн хүсэлтийг хянана.

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

LDP Compliance Flowchart



4.2.3. Байгаль орчны асуудлууд

ГХЗ-ийн хүсэлтийг зөвшөөрөх процесст анхаарах зүйлт байгаль орчны шаардлагуудад өнгөн хөрсийг хамгаалах, ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлсийг хамгаалах, ан амьтад болон тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, усны нөөц, чанарын хамгаалалт, хог хаягдлын менежментийн шаардлагууд зэрэг асуудлууд багтана. Байгаль орчны хэлтсээс өгсөн зөвлөмжийг ГХЗ-ийн Байгаль орчны хяналтын хуудасны маягтад (Хавсралт F) тусгаж Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтанд өгөх ёстой.

4.2.3.1. Ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн баг

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

Хөндөгдөөгүй, дахин ургамалжуулсан газрыг хөндөхөөр төлөвлөж буй ОТ-н удирдаж байгаа аливаа төслүүдийг хэрэгжүүлэхдээ 4.1.1 ба 4.1.2-р зүйлд заасанчлан ГХЗ-ийн хүсэлтийг ирүүлэхээсээ өмнө Ургамлын аймгийн судалгааны багтай харьцана. Төлөвлөсөн ажлын талбайд ховор ургамлын төрөлд зүйл байгаа эсэхийг шалгах урьдчилсан судалгааг энэ үед хийх бөгөөд судалгааны үр дүнгээс хамаарч биологийн олон янз байдалд нөлөөлөл учруулахтай холбоотой ОТ-н нөлөөллийг бууруулах шаталсан арга хэмжээний дагуу төлөвлөсөн ажлын талбайг өөрчилж шилжүүлэх эсэх эсвэл аюулгүй байдлын асуудал буюу бусад анхаарах асуудлуудаас хамаарч газар хөндөх үйл ажиллагааны байршлыг өөрчилж шилжүүлэх өөр сонголт байхгүй бол, ОТ-н Ховор ургамлыг хамгаалах журмын (ОТ-10-Е14-PRC-0007) дагуу бие даасан ховор ургамлуудыг жилийн тохиромжтой үед шилжүүлсэн суулгах ажлыг Ургамлын аймгийн судалгааны баг хийхэд хангалттай хугацааг төслийн төлөвлөлтийн үйл явцад оруулж өгөх эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.

Ховор ургамал, ургах орчинд дараах төрөл зүйлс багтана. Үүнд:

- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөний (ОТ-10-Е14-PLN-0003) Хавсралт 1-д тодорхойлсон 8 ховор ургамал;
- Хар шөрмөс;
- Голын хайлаас, улиангар;
- Заган ой;
- Зонхилох бэлчээрийн ургамлууд.

ГХЗ-ийн хүсэлтийг хүлээж авахад Ургамлын аймгийн судалгааны баг нь Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний журам (ОТ-0244-00-SWPO-0008), Ховор ургамлыг хамгаалах журмын (ОТ-10-Е14-PRC-0007) дагуу ГХЗ хүссэн газарт газар хөндөхийн өмнөх талбайн шалгалт хийнэ. Шалгалтын судалгаагаар цаашдын биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөлт хийх зорилгоор ургамлын бүлгүүд, хөрсний нөхцөл байдал болон бусад мэдээллийг бүртгэнэ. Цөлийн элсэрхэг, хагас цөлийн элсэрхэг буюу шаварлаг хөрстэй талбайн өнгөн хөрс нь MNS 5616:2008 стандартын шаардлагуудыг хангасан, цаашдын нөхөн сэргээлтэд зориулж хөрсийг нь хуулж, хадгалсан байх шаардлагатай ч, төлөвлөсөн ажлын хамрах хүрээнээс хамаарч өнгөн хөрсийг заавал үргэлж хуулах шаардлагагүй. Ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн баг газар хөндөхийн өмнөх талбайн шалгалт хийхдээ өнгөн хөрсийг зайлуулах шаардлагыг тодорхойлж, өнгөн хөрсийг зайлуулах шаардлагатай талбайг зургаар тодотгоно.

Ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн баг гарын үсэг зурсан ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудасны маягт дээр ховор ургамлыг хамгаалах шаардлагуудтай холбоотой бүрдүүлэлтийн мэдүүлгээс гадна өнгөн хөрс хуулах гүн, хадгалах байршил, өнгөн хөрсийг хадгалах шаардлагатай талбайн зураглал дээр тодорхой дурьдсан зөвлөмж өгнө. Зөвлөмжид тусгасан өнгөн хөрсийг нь хуулах шаардлагатай талбай, өнгөн хөрсний овоолгын байршлыг зохих төрлийн газрын зураг дээр дүрслэн үзүүлж, хяналтын хуудсанд хавсаргана.

Газар хөндөхийн өмнөх талбайн шалгалтын явцад төлөвлөсөн ажлын талбай дээр ямар нэг ховор ургамлын төрөл зүйл олдвол, төлөвлөсөн ажлын талбайг ховор ургамлын төрөл зүйл байхгүй эсвэл ховор ургамлын төрөл зүйлийн тархац багатай өөр талбай руу нүүлгэн шилжүүлэх боломжтой эсэхийг ОТ эхэлж үнэлнэ. Илэрсэн ховор ургамлыг хөндөхөөс зайлсхийх боломжгүй нөхцөлд Ургамлын аймгийн судалгааны баг илэрсэн ховор ургамлыг нэг бүрчлэн шилжүүлэн суулгах ажлыг хийнэ. Шилжүүлэн суулгалтыг амжилттай хийхийн тулд уг үйл ажиллагааг жилийн хамгийн тохиромжтой үед хийх шаардлагатай тул Ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн баг төслийг эхлүүлэхэд тохиромжтой хугацааг тайлбартаа тусгана.

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

4.2.3.2. Амьтны аймгийн судалгааны баг

Амьтны аймгийн судалгааны баг нь ГХЗ хүссэн газар нутагт амьдрах орчны үнэлгээ хийж, Газар шорооны ажлын оператор, Гүйцэтгэгч нарын хэрэгжүүлэх зэрлэг амьтдын амьдрах орчныг хамгаалах шаардлагын талаар мэргэжлийн дүгнэлт болон тодорхой заасан зөвлөмж өгнө. Амьтны аймгийн судалгааны баг дүгнэлт, тайлбартаа шувууд, хөхтөн амьтдын үүр болон бусад чухал амьдрах орчин болох боломжтой ургамлыг хөндөх асуудлыг харгалзаж үзнэ. Эдгээр газар нутагт ургамал хөндөхөөс зайлсхийх боломжгүй бол, үржлийн бус цагаар ургамал хөндөлтийг хийх ёстой. Хяналтын дүгнэлт, зөвлөмжийг гарын үсэг зурсан ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудасны маягтад тусгана.

Төслийн зохицуулах баг болон Операторууд нь Амьтны аймгийн судалгааны багаас тайлбар/дүгнэлт өгсний дараагаар зэрлэг ан амьтдыг хамгаалах, амьдрах орчныг хамгаалах тал дээр шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Зэрлэг ан амьтдыг хамгаалах нэн тэргүүний чухал зүйлс нь:

- Монгол хулан;
- Аргаль;
- Хар сүүлт;
- Жороо тоодог;
- Могойч шумбуур;

4.2.3.3. Усны нөөцийн баг

Усны нөөц баг нь усны эх хэсгийг хамгаалах мөн хяналтын цэгүүд дээр суурилуулсан байгууламжуудыг гэмтлээс сэргийлэхтэй холбоотой ГХЗ-ийн хүсэлтийн материалыг хянана. Шинжилгээнд тулгуурласан дүгнэлт болон тодорхой заасан зөвлөмжүүдийг гарын үсэг зурсан ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудасны маягтад тусгана. Төлөвлөсөн ажлын талбайд ус хамгаалах, хууль тогтоомжийн талаас ямар нэгэн асуудал эсвэл эрсдэл илэрвэл, Оюу Толгойн Усны нөөцийн баг ОТ-н Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е11-PLN-0001) болон бусад холбогдох хууль тогтоомжийн шаардлагуудад нийцүүлж хэрэгжүүлэх шаардлагатай нөлөөллийг бууруулах арга хэмжээг эсвэл тохиромжтой нүүлгэн шилжүүлэх талбайг Төслийн зохицуулах багуудад зөвлөнө. Төслийн зохицуулах багуудын хийх дүгнэлт, ойлголтод зориулагдсан тохиромжтой газрын зураг болон бусад хэрэгслүүдээр тайлбар, асуудал эсвэл эрсдэлүүдийг харуулна.

Усны асуудал хариуцсан баг мөн орон нутгийн иргэдийн ашиглах гүний болон гүехэн худаг зэрэг шинэ усны хангамжийн цэгүүдийг байгуулах ГХЗ-ийн хүсэлтийг хянахдаа Усны гидрогеологийн үнэлгээ хийнэ.

4.2.3.4. Хог хаягдал, химийн бодисын баг

ГХЗ-ийн хүсэлт гаргасан талбайд төлөвлөсөн төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй харгалзаж үзэх шаардлагатай хог хаягдал, химийн бодисын менежментийн шаардлагуудыг тодорхойлохын тулд, Хог хаягдал, химийн бодис хариуцсан ажилтан ГХЗ-ийн хүсэлтийн материалыг хянана.

Хог хаягдал, химийн бодисын менежменттэй холбоотой тайлбарууд нь голчлон төслийн хамрах хүрээ, хог хаягдал хаях байршлуудад тусгайлсан хаягдал цуглуулах арга мөн зөвшөөрөлтэй ажлын талбайд ямар нэг химийн бодис хэрэглэж буй бол химийн бодистой зохистой харьцах ажлуудыг хамардаг. Гэхдээ хог хаягдал, химийн бодисын менежментийн шаардлагууд нь ажлын хамрах хүрээнээс хамаарч харилцан адилгүй байдаг тул Газар

Хуудас 13-22

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ

ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2016-12-21

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

шорооны операторуудаар ОТ-н хог хаягдал, химийн бодистой харьцах арга барил болон хууль эрх зүйн бусад шаардлагад нийцүүлж төслийг хэрэгжүүлүүлэхийн тулд, төлөвлөсөн ажлын талбайн нарийвчилсан шинжилгээний үр дүнд тулгуурлаж тайлбар хийнэ.

Хог хаягдал, химийн бодис хариуцсан ажилтан шаардлагатай хог хаягдал, химийн бодисын менежментийн шаардлагуудыг ГХЗ-ийн байгаль орчны хяналтын хуудасны маягтад тайлбарлаж, гарын үсэг зурна.

4.2.2. Орон нутгийн харилцааны асуудлууд

Гарын үсэг зурсан ГХЗ-ийн олон нийтийн хяналтын хуудсан дээр (Хавсралт G) заасан шаардлагатай бүх сэдвээр төлөвлөсөн ажлын талаар Нийгмийн харилцааны хэлтэс дүгнэлт, санал өгнө. Сэдэвт төлөвлөсөн ажлын талаарх олон нийтийн санал бодол, дуу чимээг бууруулах үйл ажиллагаа, өвөл/зуны хашаа хороо, малчдын худаг, соёлын өвийг хөндөх болон бусад үйл ажиллагаанууд багтана.

4.2.2.1. Орон нутгийн иргэдийн санал гомдол

Бүх барилга угсралтын ажлыг зөвхөн тухайн зөвшөөрөлтэй газарт явуулах шаардлагатай бөгөөд барилгын талбайг зохих анхааруулга тэмдэглэлээр тодорхой зааж, хил хязгаарыг хашиж хамгаалсан байна.

НХ нь ГХЗ-ийн хүсэлтийг авч үзэх үе шатанд тухайн орон нутгийн холбогдох этгээд, оролцогч талуудад уг ажлын төлөвлөгөөний талаар мэдээлнэ. Энэ үед мөн тухайн орон нутгийн иргэдэд үзүүлж болзошгүй дуу шуугианы талаар мэдэгдэх шаардлагатай.

Тухайн нутгийн ойролцоох малчдын худаг, өвөлжөө, ариун дагшин газарт ямар нэгэн садаа болохгүй байх тал дээр ОТ-н зүгээс бүхий боломжит арга хэмжээг авна. Хэрэв тухайн саадыг үгүй хийх боломжгүй тохиолдолд, төслийг төлөөлөн ажиллаж буй ажилчид орон нутгийн ард иргэдтэй уг асуудлаар ярилцаж, хэлэлцэн тохиролцох бөгөөд ард иргэдтэй уулзалт зохион байгуулах асуудлыг НХ хариуцна.

4.2.2.2. Соёлын өвийг хамгаалах

Тухайн ажлын талбайд археологи, палентологийн олдвор зэрэг соёлын үнэт зүйл бүхий газар байхгүй гэдгийг эрх бүхий байгууллага тогтоон, баталгаажуулна. ОТ-н НХэлтэс нь соёлын үнэт зүйл байхгүй гэдгийг ГХЗ-ийг батлах НХ-ийн шалгах хуудсаар гаргаж Байгаль орчны хэлтэст ирүүлнэ.

ГХЗ-ийн хүсэлтийг авч үзэх үе шатанд соёлын өв, дурсгал илэрсэн тохиолдолд, Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу шаардлагатай авран хамгаалалт, малталт хийх бөгөөд тухайн ГХЗ-ийн хүсэлтийг авч үзэх асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор дээрхтэй холбоотой мэдэгдэл, дүгнэлтийг Байгаль орчны хэлтэст хүргүүлнэ. ОТ-н НХ нь малталтын ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

Хэрэв ажлын явцад археологи, палентологийн чухал ач холбогдол бүхий дурсгал, олдвор тухайн талбайд илэрвэл ОТ-н Дурсгалт зүйл олдсон тохиолдолд баримтлах журмын дагуу дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Ажилтан олдвор байгааг мэдсэн даруйд тухайн орчинд бүх газар шорооны ажлыг зогсооно.
- Ажилтан илэрсэн зүйлсийн талаар Ахлах ажилтандаа цаг алдалгүй мэдэгдэнэ.
- Мэдээлэл авсан Ахлах ажилтан ОТ-н НХ-т эсвэл Хяналтын өрөөнд нэн даруй мэдэгдэнэ.

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

- НХ–ийн Соёлын өвийн хөтөлбөрийн баг Монгол улсын Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авна.

НХ төлөвлөсөн ажлыг эхлэхээс өмнө ОТ-н Дурсгалт зүйл олдсон тохиолдолд баримтлах журмын танилцуулах сургалтыг газар шорооны ажлын операторууд болон Гүйцэтгэгч нарт хийнэ.

4.3. ГХЗ-ийг батлах

Салбарын шинжээчдийн багуудаас цуглуулсан бүх тайлбарыг анхааралтай хянасан дүгнэлтэд тулгуурлаж Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтан ГХЗ-ийн маягтын (Хавсралт Н) 2-р хэсэгт төлөвлөсөн ажлын бүх оролцогч талуудын дагаж мөрдөх шаардлагатай гэсэн шаардлагуудыг заасан зөвшөөрлийн нөхцөлийн төслийг боловсруулна.

Зөвшөөрлийн нөхцөлийг хянасныхаа дараа Байгаль орчны мэргэжилтэн ГХЗ-ийг батална.

Шаардлагад нийцэхгүй эсвэл олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарахуйц асуудлууд илэрсний улмаас татгалзсан хүсэлтүүдийг илэрсэн асуудлуудаас сэргийлэх арга хэмжээг харгалзан үзэж төслийн төлөвлөгөөг дахин боловсруулуулахаар Төслийн зохицуулах багууд руу буцааж болно. Дахин ирүүлсэн ГХЗ-ийн хүсэлтүүд нь хянах үйл явцаар дахин дамжих бөгөөд бүх боломжит асуудлууд шийдвэрлэгдсэн эсвэл нөлөөллийг бууруулах үр дүнтэй арга хэмжээнүүдийг батлах эрх бүхий удирдах албан тушаалтнууд баталсан байвал тухайн хүсэлтийг батална.

4.4. Ажлыг хэрэгжүүлэх

Төслийн зохицуулах баг батлагдсан ГХЗ-ийг хүлээн авч, ГХЗ-д шаардсан бүх нөхцөлийг газар шорооны ажил хариуцсан баг, Гүйцэтгэгчид мэдэгдсэний дараа зөвхөн төлөвлөсөн ажлыг эхлүүлж болно.

Хөрс хуулж, өнгөн хөрсийг хадгалснаар зөвшөөрөгдсөн газарт төлөвлөсөн ажил хийгдэж эхэлнэ.

4.4.1. Өнгөн хөрсийг хуулах, хадгалах

Газар шорооны ажлыг операторууд өнгөн хөрсийг хуулах, хадгалах шаардлагуудыг нарийвчлан тусгасан өнгөн хөрстэй ажиллах бүх үе шатанд Өнгөн хөрстэй ажиллах журмыг (ОТ-10-Е14-PRC-0001) баримтална. Өнгөн хөрсийг хуулах, хадгалах гол шаардлага нь дараах байдалтай байна.

4.4.1.1. Өнгөн хөрсийг хуулах

- Өнгөн хөрсийг хуулах шаардлагатай талбай нь асгарсан бодис болон хог хаягдлаас ангид байна. Өнгөн хөрсийг хуулахаас өмнө асгарсан бодисоор бохирдсон хөрсийг Оюу Толгойн Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журмын (ОТ-10-Е15-PRC-0002) дагуу тухайн талбайгаас цэвэрлэж, ОТ-н газрын аж ахуй руу тээвэрлэж аваачна.
- Ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн багийн зааж өгсөн талбай дахь өнгөн хөрсийг батлагдсан ГХЗ-д заасан гүн хүртэл нь хуулах шаардлагатай.
- Ачигчийг аажуухан хоосолж, машинд ачихдаа шанагыг ачааны тэргэнд ойр байлгаж, салхины хурд их байгаа үед өнгөн хөрс хуулах үйл ажиллагааг түр зогсоох зэргээр тоос бууруулах арга хэмжээ авна.
- Боломжтой бол өнгөн хөрсийг хөндөх газраас зөөж нөхөн сэргээх газарт шууд

Хуудас 15-22

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ

ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2016-12-21

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

шилжүүлэн суулгана.

- Өнгөн хөрсийг шууд шилжүүлэн суулгах боломжгүй эсвэл бусад зохион байгуулалтын арга хэмжээг харилцан тохиролцоогүй бол, өнгөн хөрсийг овоолго хийх зориулалттай газар руу тээвэрлэнэ.
- Бороо орж байх болон хүчтэй салхитай эсхүл хөрс хэт чийгтэй нөхцөлд өнгөн хөрсийг хуулж болохгүй.

4.4.1.2. Өнгөн хөрсийг хадгалах

- Өнгөн хөрсний овоолго хийж эхлэхээс өмнө Газар шорооны ажлын баг эсвэл Гэрээт гүйцэтгэгч өнгөн хөрсний овоолго хийх зориулалттай талбайн хил хязгаарыг тогтоох бөгөөд тухайн талбай нь асгарсан бодис болон хог хаягдлаас ангид байна. Асгарсан бодисоор бохирдсон хөрсийг Оюу Толгойн Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журмын (ОТ-10-Е15-PRC-0002) дагуу тухайн талбайгаас цэвэрлэж, ОТ-н газрын аж ахуй руу тээвэрлэж аваачна.
- Өнгөн хөрсний овоолгыг хийж эхлэхээс өмнө овоолгын талбай дахь өнгөн хөрсийг овоолгын ёроол хүртэл хадгалахын тулд овоолгын талбайн гадаргууг зохих менежер эсвэл гүйцэтгэгчийн Ахлах ажилтны баталсан багаж хэрэгсэл/тоног төхөөрөмжөөр хамгийн багадаа 50-150 мм гүнд хүртэл суулгана.
- Өнгөн хөрсийг салхи болон гадаргын усны элэгдлээс хамгаалсан байдлаар овоолно;
- Хөрсний овоолгонд хүчилтөрөгчгүй орчин бий болохоос сэргийлэх үүднээс өнгөн хөрсний овоолгын өндрийг 3м-ээс ихгүй байлгана.
- Өнгөн хөрсний овоолгыг аюултай хаягдал чулуулаг болон бусад бохирдуулах эх үүсвэрээс хол байлгах хэрэгтэй.
- Ус зайлуулах замаар овоолгын тунадас зөөгдөхөөс сэргийлнэ.
- Өнгөн хөрсний овоолгон дээр тээврийн хэрэгсэл болон бусад хүнд машин механизмын хөдөлгөөнийг хориглоно.

Өнгөн хөрс хуулалт болон овоолгын цаашдын шаардлагуудыг ОТ-н Өнгөн хөрстэй ажиллах журамд (ОТ-10-Е-14-PRC-0001) заасан.

4.4.2. ГХЗ-ийн биелэлтэд хяналт тавих

Төслийн газар шорооны ажлын операторуудын гүйцэтгэсэн бүх ажилд ОТ-н Байгаль орчны хэлтэс ГХЗ-ийн биелэлтийг хянана.

Газар шорооны ажлын операторууд эсвэл Гүйцэтгэгч нар ГХЗ-д тусгасан нөхцлийг хэрэгжүүлж байгаа эсэхийг бататгах үүднээс тус тусын Төслийн зохицуулах багууд хяналт шалгалт хийнэ. Хяналт шалгалт бүрийн дараах тайланг ГХЗ-ийн Биелэлтийн хяналт шалгалтын маягт (Хавсралт I) хэлбэрээр бэлтгэж, Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтанд хяналт шалгалт бүрийн дараа хянуулахаар цаг тухайд нь хүргүүлнэ.

ГХЗ-д заасан нөхцөлийн аливаа үл биелэлтийг байгаль орчны осол зөрчил гэж үзэх тул засаж залруулах арга хэмжээ авахуулахаар РТБШ дээр мэдээлнэ.

4.4.3. Газар шорооны ажлыг дуусгах буюу нөхөн сэргээлт

Ажлын талбайн гадны хог хаягдлыг цэвэрлэж, нөхөн сэргээлтийг (өнгөн хөрсийг зөөх, газар самнах, дахин хэлбэржүүлэх г.м) дуусгаснаар газар шорооны ажлын тоног төхөөрөмж, багийн ажилчдыг буцаан татахыг зөвшөөрнө. Эдгээр ажлыг ОТ-н Техникийн нөхөн

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PRC-0003-M	Хувилбар: 1.2

сэргээлтийн журмын (ОТ-10-E14-PRC-0002) дагуу гүйцэтгэнэ. Нөхөн сэргээлтэд зарим нөлөөллийн газар талбайд тухайн газрын унаган үр жимсийг шууд суулгах шаардлагатай тухай ГХЗ-ийн нөхцөл болзолд тусгаж болох бөгөөд энэ тухай шаардлагыг ОТ-н Ургамлын судалгаа, нөхөн сэргээлтийн баг зааварчилгаандаа тусгаж өгнө.

4.5. Техникийн нөхөн сэргээлтийн шалгалт

Нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн дуусгасны дараа Газрын асуудал хариуцсан Байгаль орчны ажилтан, Ургамлын аймгийн судалгаа, нөхөн сэргээлтийн баг мөн Нийгмийн хэлтэс хамтарч ГХЗ-ийн Гүйцэтгэлийн буюу хаалтын хяналт шалгалтыг явуулна. Хамтарсан шалгалтын баг нь ажлын талбайд гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн ажилд үнэлгээ өгч, ГХЗ-ийн Гүйцэтгэлийн хяналт шалгалтын маягтыг (Хавсралт J) ашиглан тайлан гаргана. Хэрэв нөхөн сэргээлтийн ажлыг хангалттай гэж үзвэл Байгаль орчны мэргэжилтэн нөхөн сэргээлтийн нөхцөл байдлын эцсийн тайланд гарын үсэг зурж, холбогдох талуудад мэдэгдэнэ.

Уурхайн лицензит талбайн гаднах ажлын ГХЗ-ийн Гүйцэтгэлийн хяналт шалгалтын тайланг ЭМААБО-ны Эрх зүйн хэрэгжилт хариуцсан багт шилжүүлж, тухайн нөхөн сэргээсэн газар нь олон нийт болон мал амьтдыг явахад ямар нэгэн аюул учруулахгүй гэдгийг баталгаажуулах буюу орон нутгийн удирдлагад хүлээлгэн өгөхөд боломжтой болгоно. ЭМААБО-ны Эрх зүйн хэрэгжилт хариуцсан баг дотоод шалгалтаар хүлээн зөвшөөрөгдсөн нөхөн сэргээлт хийгдсэн газрууд дээр Улсын шалгалт хийлгэх ажлыг зохицуулна.

Техникийн нөхөн сэргээлтийн шаардлагууд болон хяналт шалгалтын үйл явцын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ОТ-н Техникийн нөхөн сэргээлтийн журамд (ОТ-10-E14-PRC-0002) заасан.

4.6. ГХЗ-ийн хүсэлтийг хаах

Нөхөн сэргээлтийн ажлыг хангалттай гэж үзвэл Байгаль орчны мэргэжилтэн тухайн батлагдсан Газар хөндөх зөвшөөрлийн “Гүйцэтгэл” хэсэгт гарын үсэг зурна. Гүйцэтгэгчид эсвэл ОТ-н газар шорооны ажлын багуудыг ажлын талбайгаас буцаан татах боломжтой болгох байгаль орчны зөвшөөрөлд гарын үсэг зуруулахаар тухайн хаагдсан ГХЗ-ийн хуулбарыг нөхөн сэргээлтийн шалгалт г.м. ГХЗ-ийн Гүйцэтгэлийн хяналт шалгалтын тайлангийн хамт Төслийн зохицуулах багуудад хүргүүлнэ.

Орон нутгийн удирдлага ЭМААБО-ны Эрх зүйн хэрэгжилт хариуцсан багаас Нөхөн сэргээлтийн актыг хүлээж авахад ОТ-н Байгаль орчны хэлтсийн Газрын асуудал хариуцсан баг ГХЗ-ийг албан ёсоор хаана.

Газар хөндөх зөвшөөрлийн дараах баримт бичгийг бөглөнө. Үүнд:

- Бөглөсөн ГХЗ-ийн хүсэлтийн маягт
- Газар хөндөхийн өмнөх хяналт шалгалтын тайлан
- Газар хөндөх зөвшөөрөл
- ГХЗ-ийн байгаль орчны шалгах хуудас
- ГХЗ-ийн ЭМААБО-ны Эрх зүйн хэрэгжилтийн хяналтын хуудас
- ГХЗ-ийн орон нутгийн шалгах хуудас
- ГХЗ-ийн Биелэлтийн хяналт шалгалтын тайлан, засч залруулах арга хэмжээг хааж байгаа тухай баримт
- Нөхөн сэргээлтийн шалгалтын тайлан г.м. ГХЗ-ийн биелэлт

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

- Талбайгаас гадуурх төслүүдийн нөхөн сэргээлтийн акт зэрэг багтах бөгөөд эдгээрийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр ОТ-н Байгаль орчны хэлтсийн оффист хадгална.

5. СУРГАЛТ

Газар хөндөх зөвшөөрлийн журам болон түүний шаардлагуудын хэрэгжилт, өнгөн хөрстэй ажиллах, нөхөн сэргээлт хийх талын мэдлэгийг Байгаль орчны танилцуулах сургалт мөн ОТ-н Газрын менежментийн сургалтаар дамжуулж ОТ-н нийт ажилчид болон Гүйцэтгэгч нарт олгосон.

6. ТОДОРХОЙЛОЛТ

Хөрсний элэгдэл: Газар тариалан, орон сууц болон үйлдвэрийн бүтээн байгуулалт, зам барилгын ажилтай холбоотой газар хөндөх үйл ажиллагааны улмаас эрчимжсэн салхи, усны нөлөөгөөр газрын гадарга элэгдсэн/идэгдсэн байдал.

Газар хөндөх: Ажлын талбай дахь газрын бүрхүүл (ургамлын болон ургамлын бус) болон хөрсний байр зүй, бүтцэд өөрчлөлт оруулж буй үйл ажиллагаа. Газар хөндөх үйл ажиллагаанд бүтээн байгуулалт, барилга, нураах, цэвэрлэх, тэгшлэх, ухах болон карьерийн үйл ажиллагаа орох боловч эдгээрээр хязгаарлагдахгүй бусад олон төрлийн үйл ажиллагаа байж болно.

Газар хөндөх зөвшөөрөл: Газар хөндөх зөвшөөрөл олгох журмын дагуу төлөвлөсөн газар шорооны ажлыг эхлүүлэх эрх олгосон зөвшөөрөл.

Оюу Толгой төслийн талбай: 6709А тоот Оюу Толгойн түрээсийн талбайн бүх талбай болон Оюу Толгой ХХК-ийн гүйцэтгэх үйл ажиллагааны шууд нөлөөнд автана гэж урьдчилж тооцсон, ажлын талбайгаас гаднах талбай.

Төслийн зохицуулах баг: ГХЗ хүссэн талбайд төлөвлөсөн ажлыг зохицуулах ОТ-н баг эсвэл албан тушаалтан.

Техникийн нөхөн сэргээлт: Газар хөндөх үйл ажиллагааны байгаль орчны зайлшгүй нөлөөллийг засч залруулсан арга хэмжээ/үйл явц.

Тунадас: Өнгөн хөрс, элс болон эрдэсийн уусгалт.

Ажлын талбайн төлөвлөгөө: Тодорхой хэсэг газарт санал болгож буй бүтээн байгуулалтын ажлыг газар ашиглалтын төрөл, эрчимжилтийг үндэслэлтэйгээр тодорхой харуулсан, судалгаа шинжилгээ хийж, бэлэн болгосон график дүрслэл.

Овоолго: Элэгдэж идэгдэх материалыг нэгдсэн цэгт түр хадгалах.

Хөрс хуулах: Хөрсний давхаргыг зааж өгсөн гүнд хүртэл хуулах.

Өнгөн хөрс: Үржил шимтэй, нэн чухал органик нэгдэл, бичил организм, үр үндэс агуулсан, үндсэн чулуулгийн дээр байх газрын гадаргын хамгийн дээд талын давхарга

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

7. АШИГЛАСАН БОЛОН ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД

	Нэр	Байршил
Эрх зүйн болон бусад шаардлагууд	<ul style="list-style-type: none"> MNS 5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5917:2008. Байгаль Орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага. МУ-ын Байгаль хамгаалах тухай хууль, 1995 МУ-ын Газрын тухай хууль, 2002 МУ-ын Газрын хэвлийн тухай хууль, 1998 МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 2014 	Хуулийн бүртгэл
Оюу Толгойн ЭМААБОАБОН-ийн менежментийн систем	<ul style="list-style-type: none"> Рио Тинто E-14 Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн стандарт Ховор ургамлыг хамгаалах журам (ОТ-10-Е14-PRC-0007); Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний журам (ОТ-0244-00-SWPO-0008) Өнгөн хөрстэй ажиллах журам (ОТ-10-Е14-PRC-0001); Техникийн нөхөн сэргээлтийн журам (ОТ-10-Е14-PRC-0002); Дурсгалт зүйл олдсон тохиолдолд баримтлах журам (лавлах дугаар байхгүй); Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам (ОТ-10-Е15-PRC-0002) Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (ОТ-Е14-PLN-0005) Уурхайг хаах төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0002) Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0003) Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е11-PLN-0001) Агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е12-PLN-0001); 	ОТ портал
Маягт, Хянах цэс, Зөвшөөрөл, Эх загвар	<ul style="list-style-type: none"> ГХЗ-ийн хүсэлтийн маягтыг (Хавсралт С) ГХЗ-ийн маягт (Хавсралт Н) Газар хөндөхийн өмнөх хээрийн шалгалтын маягт (Хавсралт D) ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилтийн хяналтын хуудас (Хавсралт E) ГХЗ-ийн Байгаль орчны хяналтын хуудас (Хавсралт F) 	ОТ портал

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

	<ul style="list-style-type: none">ГХЗ-ийн олон нийтийн хяналтын хуудас (Хавсралт G)ГХЗ-ийн Биелэлтийн хяналт шалгалтын маягт (Хавсралт I)ГХЗ-ийн Гүйцэтгэлийн хяналт шалгалтын маягт (Хавсралт J)Өнгөн хөрсний удирдлагын төлөвлөгөө (Хавсралт B)	
Схем, газрын зураг	<ul style="list-style-type: none">Газар хөндөх зөвшөөрөл олгох, хаах алхмуудын дараалалГХЗ-ийн хүсэлтийг хянах ЭМААБО-ны эрх зүйн хэрэгжилтийн алхмуудын дараалалОТ-н Уурхайн лицензит талбайн ховор ургамлыг хөндөхөөс сэргийлэх талбайн газрын зураг (Хавсралт А)	Уг журмын хавсралт

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2

8. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Баримт бичгийн нэр	ОТ-10-Е14-PRC-0003-Е- Газар хөндөх зөвшөөрөл олгох журам
Тодорхойлолт	Газар хөндөх зөвшөөрөл олгох энэхүү журамд газрыг хөндөх талаар дүрэм журам гаргаж, албан ёсны зөвшөөрөл олгох явцад байгаль орчны холбогдолтой шаардлагыг тогтоодог. Энэхүү журам нь хөндөгдөөгүй, нөхөн сэргээлт хийгдсэн газарт хамааралтай.
Эх зохиогч(д)	Лувсангийн Цэцэгсүрэн
Боловсруулсан огноо	2010.02.25
Баталсан	Глен Эйнсворт , Байгаль орчны хэлтсийн менежер
Баталсан огноо	2010.04.29
Хянан өөрчилсөн дугаар	##

Эрсдлийн зэрэг	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийг үнэлэгч	Хяналт хийх хуваарь	Дараачийн хяналт хийх огноо
Дунд	2013.05.06	Баасансүрэнгийн Долгор	2 жил тутам	2018.02.28

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тухай тэмдэглэл
1.1	2012.09.01	Лувсангийн Цэцэгсүрэн	Марк Ньюби	Дуу чимээ гарах асуудлыг тусгаж, амьдрах орчны үнэлгээг сайжруулах зэргээр ГХЗ-ийн хяналтын үйл явцад Байгаль Орчин, Нийгмийн Бие Даасан Зөвлөхийн аудитын тайлбарын мөрөөр шалгасан.
1.1	2013.05.06	Лувсангийн Цэцэгсүрэн	Марк Ньюби	Ажлын стандарт журмын шинэ загварт хувилбарыг баталсан.
1.2	2016.02.29	Лувсангийн Цэцэгсүрэн	Деннис Хосак	Е14 стандартын Хамрах хүрээ, зорилгод нийцүүлэхийн тулд Зорилго хэсэгт үг сольсон; үүрэг, хариуцлагыг шинэчилсэн; арга хэмжээний дарааллын схемийг хянаж өөрчилсөн; РТ ба ОТ-н дотоод аудитын зөвлөмжүүдийг тусгасан; Гадны осол зөрчлийн шалгалтын (усны цооног) зөвлөмжийг тусгасан; Соёлын өвийн тухай хуулийн оныг шинэчилсэн; Осол зөрчил мэдээлэх шаардлагыг нэмсэн; Ашигласан материал, холбогдох баримт бичгүүдийн жагсаалтыг хүснэгт хэлбэрт оруулсан; Зээлдүүлэгчдээс ирүүлсэн 16 тайлбарыг журамд тусгасан.

Газар хөндөх зөвшөөрөл олгох журам

Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0003-М	Хувилбар: 1.2
---	--	------------------

Хавсралт А. ОТ-н Уурхайн лицензит талбайн ховор ургамлыг хөндөхөөс сэргийлэх талбайн газрын зураг

